



"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



---

**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ  
ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

РЕГИСТРИЙН ДУГААР: 2075261

---

УЛААНБААТАР  
2022 ОН



## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....  | 3  |
| 1. ОРШИЛ .....   | 4  |
| 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....   | 5  |
| 2.1 Төслийн нэр, дугаар.....   | 5  |
| 2.2 Гүйцэтгэгч байгууллага.....  | 5  |
| 2.3 Төслийн зорилго .....  | 5  |
| 2.4 Төслийн байршил .....  | 5  |
| 3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....   | 7  |
| 3.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ  | 8  |
| 3.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ .....   | 10 |
| 3.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....  | 11 |
| 3.4. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ .....  | 11 |
| 3.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ.....  | 11 |
| 3.6. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ.....   | 11 |
| 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>ГОЛ ЗОРИЛТ .....  | 13 |
| 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ .....   | 14 |
| 5.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА<br>ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                | 14 |
| 5.2. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....   | 16 |
| 5.3.ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....  | 17 |
| 5.4. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ .....  | 17 |
| 5.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....  | 18 |
| 5.6.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ<br>ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ ..... | 18 |
| 5.7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....  | 19 |
| ДҮГНЭЛТ.....   | 20 |



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

|       |  |
|-------|--|
| БОАЖЯ | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ              |
| БОАЖГ | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР            |
| НБОГ  | НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР                   |
| БОМТ  | БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН<br>ТӨЛӨВЛӨГӨӨ         |
| БОНЕУ | БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ<br>ҮНЭЛГЭЭ      |
| БОННУ | БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН<br>НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ |
| ГТБ   | ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН                        |
| ШТС   | ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ                            |



## 1. ОРШИЛ

Төсөл хэрэгжүүлэгч нь 1997 онд "ПЕТРОВИС" ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлсэн түүхтэй. Улмаар 2004 онд Монгол улсын Засгийн газраас зарласан олон улсын тендерт шалгарч, газрын тосны ууган компани болох НИК ХХК-ийг нэгтгэн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Нийт 90 гаруй инженер техникийн ажилтантай. Нийт ажиллагсдын 80 орчим хувь нь орон нутгийн ШТС-д ажиллаж байна.

Тус компани нь 2010 онд 3 га талбай бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилгыг ашиглалтад оруулж, газрын тосны бүтээгдэхүүн болон тос тосолгоо бүтээгдэхүүн хадгалдаг тус агуулах нь нийт 11250м<sup>3</sup> газрын тосны бүтээгдэхүүн нэг удаадаа хадгалах хүчин чадалтай.

Төсөл хэрэгжүүлэгч нь одоогоор 6-н төрлийн ГТБ-нийг төмөр замаар хүлээн авч автоцистернээр түгээх зориулалттай 3000 м<sup>3</sup> багтаамжтай ил байрлалтай босоо цилиндр сав 2ш, 2000м<sup>3</sup> багтаамжтай босоо цилиндр сав 1ш, 1000м<sup>3</sup> багтаамжтай босоо цилиндр сав 3ш, 50м<sup>3</sup> багтаамжтай хэвтээ цилиндр сав 4ш, технологийн шугам хоолой суллах 25м<sup>3</sup> багтаамжтай далд байрлалттай хэвтээ цилиндр сав 2ш нийт 12ширхэг сав байрлаж байна.

"Байгаль орчны хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ тухай" Монгол улсын хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал", БОАЖЯ-ны ерөнхий шинжээчийн 2018 оны 09 сарын 20 өдрийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 2018/NA004 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг баримтлан гүйцэтгэсэн юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн, бид бүхэн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулаад байна.



## 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2.1. ТӨСЛИЙН НЭР, ДУГААР

"Шинэ Дорнод" Газрын тосны бүтээгдэхүүний агуулах

### 2.2. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

**Аж ахуй нэгжийн нэр:** "НИК" ХХК

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, 5-11 тоот

**Утас:** 99082707

**Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 9019038131

**Регистрийн дугаар:** 2075216

### 2.3. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төсөл хэрэгжүүлэгч нь хэрэглэгчдэд танигдсан, хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангасан Газрын тосны бүтээгдэхүүнээр хангах байгаль орчин, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чандлан мөрдөж, хууль дүрмийг дээдлэн, Монголдоо түлш эрчим хүчний салбарын хөгжлийг тодорхойлогч болно. Монгол улсын болон Олон улсын норм дүрэм стандартын шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр хэрэглэгчдэд үйлчлэх, хэрэглэгчдэд богино хугацаанд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, ижил төрлийн үйлдвэрлэл явуулж буй компаниудын үнийн өсөлтийг тогтоон барихад уриалан манлайлж үлгэр жишээ ажиллах эрхэм зорилт тавин ажиллаж байна.

### 2.4. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Дорнод аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах "НИК" ХХК-ийн Газрын тос хадгалах агуулахын талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 380км байрладаг. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төв байрлана.

*Хүснэгт 1 Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол*

| № | Газарзүйн солбицол |            |        |
|---|--------------------|------------|--------|
|   | Х                  | Ү          | Урт    |
| 1 | 319470.94          | 5332400.19 | 151.50 |
| 2 | 319444.13          | 5333249.14 | 247.38 |
| 3 | 319687.34          | 4332596.64 | 43.15  |
| 4 | 319694.60          | 4332554.15 | 30.85  |
| 5 | 319664.12          | 5332549.08 | 111.78 |
| 6 | 319682.81          | 533238.99  | 215.02 |



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**Зураг 1. Төслийн байршлын схем зураг**



## 2.5. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

НИК" ХХК-ийн Шинэ Дорнод Нефть хангамжийн Салбар нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р багт байрлана. Нийт 100 ажилтантай. Харуул хамгаалалтын гэрээт компанитай. Баянтүмэн төмөр замын дагуу 3.0 га талбайг хамарсан барилгажилт хийгдсэн.

- Агуулахын багтаамж 11250 м<sup>3</sup>
  - 3000м<sup>3</sup> багтаамжтай БГС-3000 маркийн босоо цилиндр сав 2ш
  - 2000м<sup>3</sup> багтаамжтай БГС-2000 маркийн босоо цилиндр сав 1ш
  - 1000м<sup>3</sup> багтаамжтай БГС-1000 маркийн босоо цилиндр сав 3ш
  - 50м<sup>3</sup> багтаамжтай БГС-50 маркийн хэвтээ цилиндр сав 4ш
  - Техникийн шугам хоолой суллах 25м<sup>3</sup>-ийн багтаамжтай далд байрлалтай РГС-25 маркийн хэвтээ цилиндр сав 2ш
- 8ш вагонцистернээс ГТБ-н зэрэг буулгах, төмөр зам
- Галын усан сан
- Конторын барилга
- Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ хийх зориулалттай лаборатори, ШТСанцын барилга, "Сенстар" маркийн түгээгүүр
- Насос станцын барилга
- Авто ачих байгууламжийн саравч
- Аянга зайлуулагч, газардуулгын иж бүрэн систем
- Гэрэлтүүлэг, хяналтын камер, цахилгааны иж бүрэн систем, цахилгааны щитийн барилга
- Гүний худаг 1ш, усан сангийн барилга
- Гал унтраах, галаас хамгаалах хана, сарай
- Сав паркын хамгаалалтын бетон далан



### 3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 3.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ

Төсөл хэрэгжүүлэгчийн төслийн баримт бичиг, зураг төсөл, төслийн талбайн орчимд хийсэн судалгаа шинжилгээний үр дүн, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал, бохирдлын түвшин, агуулахын газрын тосны бүтээгдэхүүний шинж чанар зэрэгт үндэслэн магадлан жагсаах арга болох хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах үе шаттай тодорхойлов.

1. Төслийн зорилго, техник технологи, хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийж эхний ээлжид анхаарах асуудлуудыг тодорхойлохын тулд нөлөөлөл үзүүлж болохуйц бүхий л эх үүсвэрүүдийг хамруулан нөлөөлөлд өртөж болзошгүй объектууд, бүх орчныг тодорхойлон ажиллалаа.

*Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болох сөрөг нөлөөллийн эх үүсвэр (Магадлан жагсаах арга)*

| №  | Нөлөөллийн үнэлгээ хийх үед анхаарч авч үзэх асуудлууд   | Хариулт |
|----|--|---------|
| 1  | Тухайн орон нутагт физик өөрчлөл гарах эсэх  | Үгүй    |
| 2  | Усны нөөцийг ашиглах эсэх  | Тийм    |
| 3  | Усны нөөцийг хомсдолд оруулах эсэх   | Үгүй    |
| 4  | Байгалийн нөөц баялаг ашиглах эсэх   | Үгүй    |
| 5  | Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөөтэй газрын тосны бүтээгдэхүүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх эсэх                               | Тийм    |
| 6  | Хатуу хог хаягдал үүсгэх эсэх  | Тийм    |
| 7  | Шингэн хаягдал үүсгэх эсэх   | Үгүй    |
| 8  | Агаарт аливаа төрлийн бохирдуулагч бодис ялгаруулах эсэх   | Тийм    |
| 9  | Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон орон үүсгэх эсэх  | Тийм    |
| 10 | Ус бохирдуулах эсэх  | Үгүй    |
| 11 | Хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд нөлөөлөхүйц осол аваар, эрсдэл гарах эсэх  | Тийм    |
| 12 | Үйлдвэрийн байршил нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай зөрчилдөх эсэх | Үгүй    |

#### Үр дүн:

Төслийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан төсөл хэрэгжих орон нутагт физик газарзүйд өөрчлөлт гарахгүй. Газрын тосны агуулахын үйл ажиллагаанд технологийн ус ашиглахгүй зөвхөн байгууламжийн дотоод хэрэгцээнд буюу ажилчдын унд ахуйн хэрэгцээнд, агуулахын орчны цэвэрлэгээ зэрэгт ус ашиглах тул усны нөөцийг хомсдуулахгүй гэж үзэж байна.

Газрын тосны агуулах нь нийт 100 гаруй ажилчдын ахуйн хэрэглээнээс бохир ус гарах болно.

Газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, түгээх явцад зохих журмын дагуу ажиллаагүй нөхцөлд эрсдэл үүсэх нөхцөлтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлснээр төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж байна.

Сүүлийн үеийн техник технологи нэвтрүүлэн ажиллах нь ажилчдад үзүүлэх эрсдэлийг бууруулах ч гэсэн ажилчид хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллаагүйн улмаас гэмтэж бэртэх, гэнэтийн осол аваар, эрсдэл үүсэж болзошгүй.





**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Агуулахын байршлын хувьд байршлын хувьд тухайн орон нутгийн хөгжил бусад үйл ажиллагаатай зөрчилдөхгүй.

2. Анхаарах асуудлуудыг тодорхойлсны үндсэн дээр тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эрчим, цар хүрээ, хугацаа, шинж чанарыг магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар тодорхойлж тоон ба чанарын шинжилгээ хийсэн.

Байгаль орчны суурь үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шаардлага болон манай орны нөхцөлд станцын үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмжийг ашиглахад гарч байсан урьд өмнөх ажлын туршлага, үйл ажиллагаа болон агуулахад үйл ажиллагаа явуулах явцад гарч болох сөрөг нөлөөлөл, Дэлхийн банкнаас байгаль орчны үнэлгээний талаар 1991 онд гаргасан лавламж, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан гарын авлага зэргийг ашигласан болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөл зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэдэг бөгөөд сөрөг нөлөөлөл байвал "-"-ээр, эерэг нөлөөг "+"-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд ямар байхыг үзүүлдэг байна. Нөгөө нь төслийн байршил, технологийн шийдэлтэй холбоогүй төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл юм.

**Хүснэгт 3. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал**

| №  | Байгаль орчны үзүүлэлт                                | Нөлөөллүүд |          |                     | Хугацаа          |               | Давтамж |           | Эрчим  |            |          |
|--|---|------------|----------|---------------------|------------------|---------------|---------|-----------|--------|------------|----------|
|  |   | Шууд       | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж   | Буцалтгүй | Хүчтэй | Дунд зэрэг | Сулавтар |
| <b>1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны асуудал</b> |   |            |          |                     |                  |               |         |           |        |            |          |
| 1  | Орон нутаг физик өөрчлөлт гарах                       | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 2  | Усны нөөц ашиглах                                     | -          |          |                     |                  | -             |         | -         |        |            | -        |
| 3  | Усны нөөц хомсдох                                     | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 4  | Байгалийн дагалдах нөөц, баялаг хомсдох               | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 5  | Газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах хадгалах түгээх | -          |          |                     |                  | -             |         | -         |        | -          |          |
| 6  | Хатуу хог хаягдал үүсэх                               | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 7  | Шингэн хог хаягдал үүсэх                              | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 8  | Агаар бохирдуулагч бодис ялгаруулах                   | -          |          |                     | -                |               |         | -         |        | -          |          |
| 9  | Дуу чимээ, доргио чичиргээ үүсэх                      | -          |          |                     | -                |               |         | -         |        | -          |          |
| 10   | Ус бохирдуулах  | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| 11   | Осол аваар эрсдэл үүсгэх                              | -          |          |                     | -                |               |         | -         |        | -          |          |
| 12   | Хөгжлийн төлөвлөгөө, бусад үйл ажиллагаатай зөрчилдөх | x          |          |                     |                  | x             |         | x         |        |            | x        |
| <b>2. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>                  |   |            |          |                     |                  |               |         |           |        |            |          |
| 13   | Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл                        | +          |          |                     |                  | +             | +       |           |        | +          |          |
| 14   | Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөл                   | +          |          |                     |                  | +             | +       |           |        | +          |          |



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

|                      |                                 |            |          |          |           |           |           |           |          |           |           |
|----------------------|---------------------------------|------------|----------|----------|-----------|-----------|-----------|-----------|----------|-----------|-----------|
| 15                   | Ажлын байр нэмэгдэх             | +          |          |          |           | +         | +         |           |          | +         |           |
| 16                   | Хүчтэй салхи, түймэр, аюул осол | -          |          |          | -         |           |           | -         |          | -         |           |
| <b>Дүн, тоогоор</b>  |                                 | <b>16</b>  | <b>-</b> | <b>-</b> | <b>4</b>  | <b>12</b> | <b>3</b>  | <b>13</b> | <b>-</b> | <b>8</b>  | <b>8</b>  |
| <b>Дүн, хувиар %</b> |                                 | <b>100</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>25</b> | <b>75</b> | <b>19</b> | <b>81</b> | <b>-</b> | <b>50</b> | <b>50</b> |

*Тайлбар: (+) Эерэг нөлөөлөл (-) Сөрөг нөлөөлөл (х) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй*

**Байгаль орчны чанарын өөрчлөлт:** Төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт шууд байдлаар үзүүлэх нөлөөллийн 43.75% нь ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй, 18.75% нь эерэг, 37.5% нь сөрөг нөлөөтэй байна. Агуулахын үйл ажиллагааны явцад газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах, түгээх явцад дуу чимээ үүсэх, ажилчдын хэрэглээнд ус ашиглах, осол аваарын эрсдэл, агаарыг бохирдуулагч бодис ялгарах зэрэг нь дунд зэргийн эрчимтэйгээр нөлөө үзүүлж болзошгүй. Харин орон нутагт ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө үзүүлэхгүй.

**Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор:** Үйл ажиллагааны үед байгалийн өнгө төрх өөрчлөгдөн ойр орчмын газрын хөрс, ургамлын нөмрөг технологи ажиллагаатай холбоотойгоор эвдрэлд орох зэргээр шууд бөгөөд урт хугацааны нөлөөлөл бий болох ч энэ цар хүрээ багатай байна. Тухайлбал агуулахын талбайн хэмжээтэй тэнцэхүйц өөр талбайд, эсвэл сум, багийн нөхөн сэргээлт, мод, зүлэгжүүлэлт хийх шаардлагатай байгаа газарт ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэх ажлуудыг холбогдох ажилтан албан хаагчидтай хамтран хэрэгжүүлж болно.

**Эдийн засаг нийгмийн асуудал:** Нийгэм эдийн засгийн хувьд ажлын байр нэмэгдүүлэх, улсын болон орон нутгийн татварын орлого нэмэгдэх зэрэгт шууд дунд зэргийн эрчимтэйгээр эерэг нөлөөлнө. Хог хаягдлын хувьд хаягдал хатуу болон тусгай хог хаягдлыг ангилан Орон нутгийнхаа тохижилт үйлчилгээний газартай гэрээтэй байнга хамтран ажилладаг тул эерэг нөлөөллийг бий болгож байна.

### **3.2. УУР АМЬСГАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭС ҮҮСЭХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ**

Төслийн үйл ажиллагаанд уур амьсгалын дараах хүчин зүйлсийг тооцоогүйгээс Газрын тосны агуулах газрын тос, түүний бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих үед сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Гаднах агаарын тооцооны температур /хамгийн хүйтэн хоног, салхивчны тооцоо, хамгийн халуун үе/
- Ул хөрсний хөлдөлт, гэсэлтийн нормативд гүн /хөрсний шаварлаг, элсэнцэр, жижиг ширхэгт элсэн хөрс, том ширхэгт элсэн хөрс, хэвтээ гадарга дээрх цасны ачаалал/
- Салхины тооцооны их хурд /1-10 жилийн салхины тооцооны хурд/
- Салхины шахац /1-5жил/

### **3.3. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ**

Төслийн үйл ажиллагааны явцад дараах болзошгүй сөрөг нөлөөллүүд агаар орчинд үүсэх боломжтой байна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас агаар бохирдуулагч бодис ялгарч төслийн талбай орчмын агаарыг бохирдуулах



- Төсөлд ашиглах тээврийн хэрэгслүүдээс стандарт хэмжээ давсан бохирдуулагч бодис ялгарах
- Ажлын байранд тоос тоосонцор болон агаар бохирдуулагч бодисууд хуримтлагдах
- Тоног төхөөрөмж, машин техникээс дуу шуугиан гарч ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх

### **3.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаас гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:

- Үер, хур бороо, гал түймэр, аянга цахилгаан зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох үед аливаа аюул ослоос шалтгаалан нефтийн бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалалт, түгээлт үйл ажиллагаанаас, нефтийн бүтээгдэхүүн асгарах улмаар гадаргын усанд орох, гадаргын ус хур борооны урсан өнгөрөх урсцыг бохирдуулах
- Хадгалалтын горим алдагдах, Нефтийн бүтээгдэхүүн савнаасаа асгарсан, шүүрсэн, нэвчсэн эсэхийг сайн нягтлалгүйгээр агуулахад хадгалах, хатуу хог хаягдлыг зориулалтын хог хаягдлыг цэгт төвлөрүүлээгүйгээс хур борооны усаар угаагдах
- Газрын тос, түүний бүтээгдэхүүний агуулахын үйлдвэрлэлийн хаягдал усыг үйлдвэрийн –хурын ус зайлуулах цооногоос өөр талбайд хаях

### **3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Нефтийн бүтээгдэхүүний алдагдал, агаар мандал дахь ууршилтын хэмжээнээс хамаарч тухайн орчны хөрс бүрхэвчид дараах нөлөөллийг үзүүлнэ.

Үүнд:

- Хөрсний ялзмагийн бодисын хэмжээг багасгах
- 4 этилт хар тугалга бий болгон бохирдуулагч эх үүсвэр болох
- Хөрсөн дэх нефть бүтээгдэхүүний зардлаас үүдэн ургамлын өсөлт зогсох
- Ургамлын эд, эс мутацад орох
- Хөл газрын, ургамал зарим хогийн ургамлын акселераци бий болох
- Эцэстээ, тухайн орчин дахь хөрс, ургамлын бүрхэвч устахад хүрнэ.

### **3.6. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ**

Төслийн талбайд шатахуун их хэмжээгээр хальж асгарах, тос тосолгооны материал алдагдсан тохиолдолд тэр нь тарж хөрсөөр дамжин хөрсний бохирдуулах, цас борооны усаар дамжин ихээхэн талбайг хамран хөрсөнд нэвчин бохирдол үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй.

- Сав, тоног төхөөрөмжийн гэмтлийг урьдчилан тодорхойлж, засварыг богино хугацаанд хийх бэлтгэл (аваарын бүс, заглушка, шаварлаг материал бэлтгэх г.м)-тэй байх
- Савны ёроолын хэсэг, ханын зузааныг нарийн мэдрэмтгий багажаар тодорхойлох, оношлох, засварлах



- Савнуудыг зэврэлтээс хамгаалах аргуудаас тохирсон аргыг сонгон авч хэрэгжүүлэх арга хэмжээ авч хэмжээ авах,
- Дамжуулах шугам хоолойн битүүмжлэлийг байнга хянаж байх ба түүнийг зэврэлтээс хамгаалах арга хэмжээ авах
- Савны парк, ачих, буулгах талбайд хийсэн далангийн тогтворжилтыг байнга хангаж, засварлах байх
- Савны парк, буулгах эстакад, тос бусад шингэний агуулах, савлагааны байр, шугам хоолойн хэсгүүд дэх газрын гадаргыг 8 см-ээс багагүй зузаантай, нефтийн бүтээгдэхүүнд тэсвэртэй материалаар, хучилт хийх буюу цардах, цардсан талбай нь өөр дээрээ асгарсан нефтийн бүтээгдэхүүнийг цуглуулах боломжтой тодорхой хэвгийтэй, цугларсан бохир усыг тусгай хоолойгоор дамжуулан цэвэрлэх байгууламжид хүргэх боломжийг хангасан байх

### **3.7. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ**

Шатах, тослох материал, Газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах хадгалах, түгээх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаяхад хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэйн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг оноот үнэлгээний аргаар боловсруулсныг доор үзүүлэв. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүн түгээх авто машины хөдөлгөөн, хөрсний элэгдэл талхагдлаас туруутан болон хөхтөн амьтад дайжин, хөрсөнд амьдрагч ашигт шавж амьтдын тоо цөөрөх
- Хөрсний үржил шим буурч, ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор мал, амьтдын тэжээлийн хомсдол бий болж нутаг сэлгэх үйл явц илрэх



#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

"НИК" ХХК-ний "Шинэ Дорнод" агуулах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаал, 2019 оны А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын шаардлагад нийцүүлж боловсруулав.

*Хүснэгт 4. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа*

| № | Ажлын нэр  | Зардал (мян.төг) |
|---|--|------------------|
| 1 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал            | 1 350.0          |
| 2 | Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал     | 700.0            |
| 3 | <b>Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал</b> | <b>2 050.0</b>   |

## 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"НИК" ХХК-ний "Шинэ Дорнод" агуулах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаал, 2019 оны А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын шаардлагад нийцүүлж боловсруулсны дагуу менежментийн төлөвлөгөөний биелэлтийн боловсруулав.

*Хүснэгт 5. БОМТөлөвлөгөөний зардлын задаргааны биелэлт*

| № | Ажлын нэр  | Зардал (мян.төг) | Биелэлтийн зардал (мян.төг) |
|---|--|------------------|-----------------------------|
| 1 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал            | 1 350.0          | 2 149 319                   |
| 2 | Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал     | 700.0            | 700 000                     |
| 3 | <b>Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал</b> | <b>2 050.0</b>   | <b>2 849 319</b>            |

### 5.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь 2022 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

"Шинэ Дорнод агуулах" төслийн сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд агуулахын хашаанд ургасан зэрлэг өвс ургамалыг цэвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийт 400 000 төгрөг зарцуулсан.

*Нэгдсэн журмаар салбарын нийт ажилчдыг хамруулж зохион байгууллаа.*





**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Вагон эстакадын ар талыг цэвэрлэж байгаа байдал**



**Захиргааны ажилтан, Шатахуун түгээх станц, Агуулах, Шатахуун тээврийн ажилчид уг цэвэрлэгээний ажилд бүрэн хамрагдлаа.**



**Нийт ажилчдыг 4-н баг болгон хувиарлаж ажиллуулав.**



## 5.2. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2022 оны БОМТ-ны ногоон байгууламж нөхөн сэргээлтийн зардлыг Шинэ Дорнод агуулахын хашаанд Чацарганы мод, тарьж тохижуулсан ба ногоон байгууламжыг хашаа хийж хамгаалсан. Нийт зардал 450 000 төгрөг зарцуулсан.



*Зураг 2. Чацарганы мод тарьж ургуулсан байдал*



### 5.3. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт байрлана. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрсэн үед мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, арга хэмжээ авна.

### 5.4. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг түгээх, тээвэрлэх, хадгалах явцад технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал нефтийн гаралтай бүтээгдэхүүний хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байх зайлшгүй шаардлагатай.

Газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, буулгах ажлыг ачаалал, хөл хөдөлгөөн харьцангуй багатай үед гүйцэтгэх нь тохиромжтой. Нефтийн гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, түгээхэд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд бэлэн байдлыг хангах, осол эрсдэлээс хамгаалах, хоргүйжүүлэх, саармагжуулах, гал унтраах арга хэмжээг шуурхай авах нөхцөлийг бүрэн бүрдүүлэх шаардлагатай.

#### Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

ГТБ-ны агуулахын үйл ажиллагааны явцад осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Гал унтраах тактикийн сургуульд оролцсон бие бүрэлдэхүүн





**Хүснэгт 6. Эрсдлийн менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт**

| №  | Ажлын үе шат   | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний биелэлт  |
|----|--|--|---|
| 1. | ГТБ-ын үйл ажиллагааны үед гарч болзошгүй сөрөг нөлөөлөл | - Осол эрсдлийн сургалт зохион байгуулах   | - Аврах гал утгарах 52-р ангитай хамтарсан сургалт зохион байгуулсан. |

- Аврах 52-р ангитай хамтарсан сургалт / Аврах 52-р анги/ 499 019 төгрөг

**Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 499 019 төг зарцуулав.**

#### **5.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Ахуйн хог хаягдал:** ГТБ-ны агуулах нь шатахууныг хадгалах түгээх үйл ажиллагааг хүн өдөрт 6 хүн ажиллана. Агуулахаас ажилчдын ахуйн хог хаягдал, хэрэглээнээс гарсан бичгийн цаас, хоол хүнсний хаягдал, хүмүүсийн эдэлж, хэрэглэж байсан эд, гутал хувцасны уранхай, тасархай болон бусад эд зүйлс гарах бөгөөд нэг хүнээс хоногт **1.5кг хуурай хог хаягдал гарна гэж тооцвол үйлдвэрээс 9кг/хоног, 750кг/сар, 3240кг/жил хог хаягдал гарна.**

**Хатуу хогийг цуглуулах, зайлуулах:** Агуулахын ахуйн хэрэглээнээс гарч байгаа хатуу хог хаягдлыг зориулалтын тасалгаатай, тагтай саванд цуглуулж аймгийн ТҮК-тай гэрээ байгуулан 30 хоногт нэг удаа ачуулж байх хэрэгтэй.

**Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт**

| №  | Ажлын үе шат  | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний биелэлт                                  |
|----|---|--|---|
| 1. | ГТБ агуулахын үйл ажиллагааны үед гарч болзошгүй сөрөг нөлөөлөл | - Тогтмол хугацаанд тээвэрлэж хаяж байх    | - Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай гэрээтэй ажилладаг. |

- Хатуу хог хаягдал тогтмол Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т тогтмол ачуулдаг. Сард- 50 050 төгрөг /жилд нийт 555 500/ төгрөг.

**Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 555 500 төг зарцуулав.**

#### **5.6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:** Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг нийслэлийн БОГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийнхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, ОБГ, МХГ зэрэг газруудаар станц дээрээ хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

**Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний биелэлт**

| №  | Ажлын үе шат  | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний биелэлт                                  |
|----|---|--|---|
| 1. | ГТБ агуулахын үйл ажиллагааны үед гарч болзошгүй сөрөг нөлөөлөл | - Ажилчдыг тогтмол үзлэгт хамруулах        | - Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Агуулахын 6 ажилтанг |

- Агуулахын ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан / Хорго Номин Эрдэнэ ХХК / төлбөр / 244 800/ төгрөг

**Уг ажлын зардалд 244 800 төг зарцуулсан.**

**5.7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

“НИК” ХХК-ний “Шинэ Дорнод” агуулах төслийн БОХШХ-г Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлалыг хангасан багаж тоног төхөөрөмжөөр хяналт шинжилгээг гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд ус, хөрс, агаарын хяналт шинжилгээг эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн бөгөөд ундны уснаас усны ерөнхий хими, 1 цэгт хөрсөнд хүнд элементийн шинжилгээ, агаарын 1 цэг тоосжилт РМ 2.5, РМ 10, SO, NO<sub>2</sub> газар дээр нь хэмжилт хийлгэсэн болно. Уг ажлын мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд нийт **700 000 төг** зарцуулсан.



## ДҮГНЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч "НИК" ХХК-ний "Шинэ Дорнод" агуулах төсөл нь Дорнод аймгийн Хэрлэн сум 8-р багийн нутаг дэвсгэр хэрэгжиж байна.

Тус төсөл хэрэгжүүлэгчийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2020 онд БОННУ-ний эрх бүхий "Экологийн бүтээмж" ХХК, хийж гүйцэтгэсэн бөгөөд "Шинэ Дорнод агуулах төсөл"-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хууль, Монгол улсын засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.01.06-ны өдрийн А-05 дугаар тушаал, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаалуудыг үндэслэн 2022 оны 4-р улиралд станцын ойр орчинд судалгаа, шинжилгээ, дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн тайланг боловсруулсан.

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх мөн төсөл хэрэгжиж буй Аймгийн байгаль орчны газарт БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жилд 1 удаа хийх хуваарьтай тул "НИК" ХХК-ийн "Шинэ Дорнод агуулах" төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийг энэхүү тайланд тусган харууллаа.

Төслийн талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу агаар орчин, хөрсөн бүрхэвч, ургамлын судалгааны төлөвлөгөөг 100 % даган мөрдөн биелүүлсэн.



"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

## **ХАВСРАЛТ МАТЕРИАЛ**



"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
 ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ШИНЭ ДОРНОД АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
 МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хууль зүйн сайдын 2016 оны  
 А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС  
 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000148085

2005.10.22

/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011250037

/ Хувийн хэргийн дугаар /

2075261

/ Регистрийн дугаар /

НИК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

1994.07.22

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

4661

/ код /

Нефть, нефтийн бүтээгдэхүүн шингэрүүлсэн хийн гадаад, дотоод худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4329

4520

4330

Нефтийн тоног төхөөрөмжийн худалдаа, засвар үйлчилгээ

Автомашинны засвар үйлчилгээ

Агуулах, шатахуун түгээх станц барих, засварлах

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

1,800,000.0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /


Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 00, Утас1: 330707, Утас2: 328090, Факс: 327288

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Гэрчилгээ дахин олгосон

2017 он 8 сар 29 өдөр



Оюуны өмч, улсын бүртгэлийн  
 ерөнхий газар Хуулийн этгээдийн  
 бүртгэлийн газар

/ Бүртгэсэн байгууллагын нэр /



**"НИК" ХХК-НИЙ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ  
